



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 1/131

Дэлгэрхаан сум

Шувуудын зүй бус хорогдлыг бууруулах
цахилгааны шугамын хамгаалалт хийхэд
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын 3.6.4, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны 34 дүгээр тоогтоолын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас төсөвлөсөн ажлын төлөвлөгөөний дагуу зарцуулж, амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, амьдрах орчинг сайжруулах зорилгоор шувуудын зүй бус хорогдлыг бууруулах цахилгааны шугамын хамгаалалт хийх ажлыг эхлүүлэхэд зардал гаргасугай.

2.Цахилгаан тулгуурт хамгаалалт хийх ажилд шаардлагатай 12,211,400 (арван хоёр сая хоёр зуун арван нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгнөөс эхний санхүүжилтээр 70 хувь буюу 8,547,980 (найман сая таван зуун дөчин долоон мянга есөн зуун наяд) төгрөг, ажил гүйцэтгэж ажлын хэсэгт хүлээлгэн тайлангаар баталгаажсны дараа 30 хувь буюу 3,663,420 (гурван сая зургаан зуун жаран гурван мянга дөрвөн зуун хорь) төгрөгийг дансанд шилжүүлсүгэй.

3.Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийгдэж буй судалгаа хийх ажлыг чанартай зохион байгуулж, ажлын тайлан, судалгааг фото зургаар баталгаажуулж гаргаж ирүүлэхийг ажиллахыг "Монголын Шувуулахуй холбоо" төрийн бус байгууллагын захирал (Д.Отгонсайхан), хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (У.Ариунтуяа), байгаль хамгаалагч (Х.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

4.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 2А-гийн 1.2-т заасны дагуу санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан (О.Анхцэцэг)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо) нарт даалгасугай.

ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН



2325010386